



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/328
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.


Зөрчилгүй санал дүгнэлт

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц. Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ





ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын САГ-ын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд
Утас: 261885
Цахим хаяг:
boldch@audit.gov.mn
Аудитор: П.Цэнгүүн
Утас: 261885
Цахим хаяг:
tsenguunp@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

2017 оны 2 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/24/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 14-нөөс 2017 оны 2 дугаар сарын 22-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын ОНАА-ы ахлах аудитор Ц.Цэрэнхүү, аудитор П.Цэнгүүн, аудитор Р.Цолмон нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 24-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 2 дугаар сарын 14-нөөс 2017 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь үндсэн үйл ажиллагааны хүрээнд “Харилцаа холбооны тухай”, “Радио долгионы тухай”, “Шуудангийн тухай хуулиуд”, “Цахим гарын үсгийн тухай хууль”, зэрэг хуулиуд, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагааны хүрээнд Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол улсын Ерөнхий Сайдын 2016 оны 69 дүгээр захирамжид “Харилцаа холбоо, мэдээллийн технологи, шуудангийн үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэн Монгол Улсын XXI зууны хөгжлийн үндсэн хурдасгуур болгож, мэдлэг оюунд тулгуурласан мэдээлэлжсэн нийгмийг хөгжүүлэхэд оршино” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны эрхэм зорилгыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын

уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 12-ыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан газрын даргын 2014 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 219 тоот тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн боловч зарим хүчин төгөлдөр бус эрх зүйн акт, журмыг мөрдөхөөр заасан байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна. Материаллаг байдлын түвшинг нийт орлогын 2 хувиар тооцож 130.9 сая төгрөгөөр тогтоов.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар нь 2016 онд 5,134.5 сая төгрөгийн урсгал төсвийг зарцуулахаар төсвийн тодотголоор батлагдаж 5,127.8

сая төгрөгийн санхүүжилт хийгдэж 6.7 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Үүнээс бараа ажил үйлчилгээний зардал 533.4 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардал 4,582.1 сая төгрөгийн тус тус гүйцэтгэлтэй ажилласан байна.

Шилэн дансны мэдээлэл

Тус газар нь “Шилэн дансны тухай” хуулийн дагуу өөрийн байгууллагын вэб сайтад шилэн данс цэсийг үүсгэн, www.shilendans.gov.mn сайттай холбож, уг цэсэнд байгууллагын 2017 оны батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн гүйцэтгэл, хагас жилийн санхүүгийн тайлан тухай бүрт нь байршуулж байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 4 эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үйлчлүүлэгчээс авсан судалгаа, тоон мэдээлэл, тайлбар, тодорхойлолт, нотлох баримтуудыг санхүүгийн СТАУС програмд татаж хавсаргав.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, бичиг хэрэг, шуудан холбоо, урсгал засвар зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Дуусаагүй үйлдвэрлэл дансны эхний үлдэгдэл 30,501.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 665.6 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл 31,167.4 сая төгрөг болсон байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон ажил үйлчилгээ одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байсаар байна.

Шийдвэрлэсэн: Дуусаагүй үйлдвэрлэл дансанд удаан хуримтлагдсан үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

2.Байгууллагын шинэ бүтцээр хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба байгуулагдан ажиллаж байгаа боловч хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлд түлхүү анхаарч ажиллан дотоод аудитын чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Дотоод аудит хариуцсан нэгж бүтэцтэй ажиллаж байгаа тохиолдолд тус албаны ажиллах нөхцөлийг сайжруулан ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, дотоод аудитыг хөгжүүлэн, дэмжиж ажиллах талаар зөвлөмж өгөх.

3. Урсгал засварын зардлаас 0.8 сая төгрөг, шуудан холбооны зардлаас 0.6 сая төгрөг нийт 1.4 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад санхүүжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээ хийхгүй байх талаар аудитын зөвлөмж өгөх

4.Газрын даргын тушаалаар томилогдсон тооллогын комисс жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч үндсэн хөрөнгийг түүвэрлэн хяналтын тооллого хийхэд компьютер, тоног төхөөрөмжийн тоо зөрөөгүй боловч нэр, марк, хүчин чадал зөрсөн зөрчил дутагдал илэрлээ.

Шийдвэрлэсэн: Үндсэн хөрөнгийн тооллогыг дахин хийж нэр, марк, хүчин чадлын зөрүү гарсан шалтгааныг тогтоож, энэхүү зөрүүг арилгах талаар зөвлөмж өгөх.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Төрийн аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т “Энэ хуулийг төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад дагаж мөрдөнө” гэж заасныг цаашид мөрдөж ажиллан

санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг биелүүлж ажиллах хэрэгтэй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 31,168.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 31,168.8 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 3 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 2 зөвлөмж биелээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Дуусаагүй үйлдвэрлэл.....	2
Асуудал 2	
Дотоод аудит	3

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1	
Зардал.....	4
Асуудал 2	
Үндсэн хөрөнгө.....	5

2017 оны 2 дугаар сар

2010 оны 3 дугаар сарын
01

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбат, ерөнхий нягтлан бодогч О.Наранбаатар болон санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Дуусаагүй үйлдвэрлэл	Тэргүүлэх ач холбогдол №1
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Дуусаагүй үйлдвэрлэл дансны эхний үлдэгдэл 30,501.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 665.6 сая төгрөгөөр нэмэгдэж 2016 оны жилийн эцсийн үлдэгдэл 31,167.4 сая төгрөг болсон байна. Дуусаагүй үйлдвэрлэл дансанд олон жил хуримтлагдсан, бичиг баримтын бүрдэл дутуу, шилжүүлэхэд бэлэн болсон ажил үйлчилгээ одоог хүртэл шийдвэрлэгдээгүй байсаар байна.

ҮАГ-ын зөвлөмж

Дуусаагүй үйлдвэрлэл дансанд удаан хуримтлагдсан үндсэн хөрөнгийг холбогдох байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээ авах.

Эрсдэлүүд

Байгууллагын удирдлагаас санхүүгийн тайлангаараа дамжуулан гаргаж ирдэг оршин байх, үнэн зөв байх батламж мэдэгдлүүд зөрчигдөх,

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Дотоод аудит	Тэргүүлэх ач холбогдол №1
--------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Байгууллагын шинэ бүтцээр хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба байгуулагдан ажиллаж байгаа боловч хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлд түлхүү анхаарч ажиллан дотоод аудитын чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.6-д “Төсвийн шууд захирагч нь дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна

ҮАГ-ын зөвлөмж

Дотоод аудит хариуцсан нэгж бүтэцтэй ажиллаж байгаа тохиолдолд тус албаны ажиллах нөхцөлийг сайжруулан ажилтнуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, дотоод аудитыг хөгжүүлэн, дэмжиж ажиллах.

Эрсдэлүүд

Байгууллагын санхүүгийн удирдлага, хяналт, зохион байгуулалт сулрах.

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 1: Зардал**Тэргүүлэх ач холбогдол №2****ҮАГ-ын ажиглалт**

Урсгал засварын зардлаас 0.8 сая төгрөг, шуудан холбооны зардлаас 0.6 сая төгрөг нийт 1.4 сая төгрөгийн зардлыг анхан шатны баримтын бүрдэл дутуу байхад санхүүжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Анхан шатны баримтын бүрдэлд үндэслэн ажил гүйлгээг хийж хэвших, НББ-ийн тухай хуулийн 13.7-д засныг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, орлого зарлагын гүйцэтгэл буруу илэрхийлэгдэх, төсвийг зориулалт бусаар зарцуулах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Үндсэн хөрөнгө	Тэргүүлэх ач холбогдол №2
----------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Газрын даргын тушаалаар байгуулагдсан тооллогын комисс жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогыг хийсэн боловч үндсэн хөрөнгийг түүвэрлэн хяналтын тооллого хийхэд компьютер, тоног төхөөрөмжийн тоо зөрөөгүй боловч нэр, марк, хүчин чадал зөрж байна.

.

ҮАГ-ын зөвлөмж

Үндсэн хөрөнгийн тооллогыг дахин хийж нэр, марк, хүчин чадлын зөрүү гарсан шалтгааныг тогтоож, энэхүү зөрүүг арилгах.

Эрсдэлүүд

Хөрөнгө дутагдах.

Бүртгэлд байгаа хөрөнгө өөрийн эзэмшилд биетээр байхгүй байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	30,975,161,469.73	31,519,330,289.73
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	472,920,306.76	350,685,539.76
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	472,920,306.76	350,685,539.76
3121	Төгрөг	472,920,306.76	350,685,539.76
31211	Төрийн сангийн харилцах	472,920,306.76	350,685,539.76
35	БАРАА МАТЕРИАЛ	30,502,241,162.97	31,168,644,749.97
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	30,501,786,662.97	31,167,405,799.97
354	Хангамжийн материал	454,500.00	1,238,950.00
35410	Бичиг хэргийн материал	454,500.00	624,350.00
35420	Аж ахуйн материал		614,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	43,093,996.79	21,371,472.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	43,093,996.79	21,371,472.90
392	Биет хөрөнгө	42,412,644.78	20,973,607.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	60,976,000.00	60,976,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(60,976,000.00)	(60,976,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	99,439,802.02	99,439,802.02
39206	Хуримтлагдсан элэгдэл	(82,950,397.03)	(97,015,822.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,573,449.81	55,573,449.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,650,210.02)	(37,023,821.42)
393	Биет бус хөрөнгө	681,352.01	397,865.35
39301	Програм хангамж	6,686,524.01	6,686,524.01
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,005,172.00)	(6,288,658.66)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	31,018,255,466.52	31,540,701,762.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	739,149,000.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	739,149,000.00	-
411	Богино хугацаат үнэт цаас	739,149,000.00	-
4111	Төгрөг	739,149,000.00	-
41112	Бусад үнэт цаас	739,149,000.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	30,279,106,466.52	31,540,701,762.63
51	Засгийн газрын хувь оролцоо	30,279,106,466.52	31,540,701,762.63
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	297,274,203.04	297,274,203.04
51101	Өмч: - төрийн	297,274,203.04	297,274,203.04
512	Хуримтлагдсан үр дүн	29,969,951,191.49	31,231,546,487.60
51210	Өмнөх үеийн үр дүн	44,041,334,164.27	29,969,951,191.49
51220	Тайлант үеийн үр дүн	(14,071,382,972.78)	1,261,595,296.11
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,881,071.99	11,881,071.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	31,018,255,466.52	31,540,701,762.63

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	8,317,414,957.00	6,546,535,167.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,317,414,957.00	6,546,535,167.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,114,481,670.00	6,539,232,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,099,506,670.00	5,134,464,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	14,975,000.00	1,404,768,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	199,224,456.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	199,224,456.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,708,831.00	7,302,767.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,708,831.00	7,302,767.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	22,388,797,929.78	5,284,939,870.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,388,797,929.78	5,284,939,870.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,928,459,700.75	4,511,417,903.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,516,847.28	410,944,500.00
210101	Үндсэн цалин	398,423,847.28	383,851,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,093,000.00	27,093,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,809,300.00	45,203,800.00
210201	Тэтгэврийн даатгал	46,809,300.00	45,203,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,709,470.00	17,201,400.00
210301	Гэрэл, цахилгаан	7,060,570.00	7,633,000.00
210302	Түлш, халаалт	4,779,720.00	5,385,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,869,180.00	4,182,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22,986,857.68	28,798,581.00
210401	Бичиг хэрэг	4,602,080.00	8,861,120.00
210402	Тээвэр, шатахуун	4,820,000.00	6,270,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,349,557.68	7,774,044.42
210404	Ном, хэвлэл	825,500.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,389,720.00	5,893,416.58
2105	Нормативт зардал	-	88,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		88,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,231,650.00	15,501,242.00
210604	Урсгал засвар	15,231,650.00	15,501,242.00
2107	Томилолт, зочны зардал	14,952,560.00	3,472,790.00
210701	Гадаад албан томилолт	6,861,850.00	
210702	Дотоод албан томилолт	3,525,750.00	2,263,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,564,960.00	1,209,190.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,374,189,676.00	3,968,484,667.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,490,084,300.00	2,254,876,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	463,320.00	1,033,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	293,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,000.00	47,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,500,000.00	
210813	Бусад зардал /ТӨҮГ/	16,878,943,556.00	1,712,234,767.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,063,339.79	21,722,523.89
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,063,339.79	21,722,523.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	460,338,229.03	773,521,967.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	424,783,128.30	747,224,786.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	424,783,128.30	747,224,786.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,117,816.45	19,582,167.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,708,831.00	7,302,767.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,279,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,408,985.45	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,437,284.28	6,715,014.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,437,284.28	6,715,014.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,071,382,972.78)	1,261,595,296.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,071,382,972.78)	1,261,595,296.11

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	8,317,414,957.00	6,546,535,167.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,317,414,957.00	6,546,535,167.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,114,481,670.00	6,539,232,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	8,099,506,670.00	5,134,464,300.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	14,975,000.00	1,404,768,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	199,224,456.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	199,224,456.00	
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	3,708,831.00	7,302,767.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,708,831.00	7,302,767.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	8,703,079,956.99	6,668,769,934.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,703,079,956.99	6,668,769,934.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,242,741,727.96	5,895,247,967.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,516,847.28	410,944,500.00
210101	Үндсэн цалин	398,423,847.28	383,851,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,093,000.00	27,093,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,809,300.00	45,203,800.00
210201	Тэтгэврийн даатгал	29,787,800.00	28,766,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,404,300.00	3,287,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,255,400.00	4,109,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	851,000.00	821,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,510,800.00	8,218,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,709,470.00	17,201,400.00
210301	Гэрэл, цахилгаан	7,060,570.00	7,633,000.00
210302	Түлш, халаалт	4,779,720.00	5,385,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,869,180.00	4,182,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,051,637.68	23,101,994.42
210401	Бичиг хэрэг	5,056,580.00	9,004,450.00
210402	Тээвэр, шатахуун	4,820,000.00	6,270,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,349,557.68	7,827,544.42
210404	Ном, хэвлэл	825,500.00	-
2105	Нормативт зардал	-	88,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		88,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23,986,270.00	21,246,005.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,754,620.00	5,447,763.58
210604	Урсгал засвар	15,231,650.00	15,798,242.00
2107	Томилолт, зочны зардал	14,952,560.00	4,209,100.00
210701	Гадаад албан томилолт	6,861,850.00	-
210702	Дотоод албан томилолт	3,525,750.00	2,263,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,564,960.00	1,945,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,700,715,643.00	5,373,252,767.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,490,084,300.00	2,254,876,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	463,320.00	1,033,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	293,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,000.00	47,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,500,000.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	3,205,469,523.00	3,117,002,867.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	460,338,229.03	773,521,967.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	424,783,128.30	747,224,786.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	424,783,128.30	747,224,786.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	32,117,816.45	19,582,167.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,708,831.00	7,302,767.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		12,279,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,408,985.45	
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,437,284.28	6,715,014.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,437,284.28	6,715,014.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(385,664,999.99)	(122,234,767.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(385,664,999.99)	(122,234,767.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	858,585,306.75	472,920,306.76
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	472,920,306.76	350,685,539.76

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	44,041,334,164.27		44,350,489,439.30
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	44,041,334,164.27	0.00	44,350,489,439.30
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-14,071,382,972.78		-14,071,382,972.78
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	29,969,951,191.49	0.00	30,279,106,466.52
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	29,969,951,191.49	0.00	30,279,106,466.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	29,969,951,191.49	0.00	30,279,106,466.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			1,261,595,296.11		1,261,595,296.11
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	297,274,203.04	11,881,071.99	31,231,546,487.60	0.00	31,540,701,762.63

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,049,906,670.00	8,111,194,213.71	5,134,464,300.00	5,127,749,286.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,099,506,670.00	8,096,219,213.71	5,134,464,300.00	5,127,749,286.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,039,365,370.00	5,036,772,204.96	2,784,959,500.00	2,778,245,100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	425,541,300.00	425,516,847.28	410,944,500.00	410,944,500.00
210101	Үндсэн цалин	398,448,300.00	398,423,847.28	383,851,500.00	383,851,500.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,093,000.00	27,093,000.00	27,093,000.00	27,093,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,809,300.00	46,809,300.00	45,203,800.00	45,203,800.00
210201	Тэтгэврийн даатгал	46,809,300.00	46,809,300.00	28,766,100.00	28,766,100.00
210202	Тэтгэмжийн даатгал			3,287,500.00	3,287,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал			4,109,400.00	4,109,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал			821,900.00	821,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал			8,218,900.00	8,218,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,709,470.00	15,709,470.00	17,201,400.00	17,201,400.00
210301	Гэрэл, цахилгаан	7,060,570.00	7,060,570.00	7,633,000.00	7,633,000.00
210302	Түлш, халаалт	4,779,720.00	4,779,720.00	5,385,600.00	5,385,600.00
210303	Цэвэр, бохир ус	3,869,180.00	3,869,180.00	4,182,800.00	4,182,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,005,120.00	23,721,307.68	30,700,200.00	28,549,758.00
210401	Бичиг хэрэг	4,707,660.00	4,971,630.00	5,088,400.00	9,004,450.00
210402	Тээвэр, шатахуун	4,671,812.00	4,820,000.00	6,269,100.00	6,270,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,961,208.00	4,349,557.68	6,476,700.00	7,827,544.42
210404	Ном, хэвлэл	825,500.00	825,500.00		
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,838,940.00	8,754,620.00	12,866,000.00	5,447,763.58
2105	Нормативт зардал	-	-	88,400.00	88,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл			88,400.00	88,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,414,300.00	14,816,600.00	20,342,200.00	15,798,242.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			172,800.00	
210604	Урсгал засвар	14,414,300.00	14,816,600.00	20,169,400.00	15,798,242.00
2107	Томилолт, зочны зардал	14,992,180.00	14,952,560.00	4,040,000.00	4,209,100.00
210701	Гадаад албан томилолт	6,861,850.00	6,861,850.00		
210702	Дотоод албан томилолт	3,525,750.00	3,525,750.00	1,801,700.00	2,263,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	4,604,580.00	4,564,960.00	2,238,300.00	1,945,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,496,893,700.00	4,495,246,120.00	2,256,439,000.00	2,256,249,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,496,231,900.00	4,494,584,300.00	2,255,076,000.00	2,254,876,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	463,300.00	463,320.00	1,033,000.00	1,033,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	193,500.00	193,500.00	300,000.00	293,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	5,000.00	5,000.00	30,000.00	47,300.00
212	ТАТААС	2,606,255,000.00	2,606,254,895.00	1,590,000,000.00	1,590,000,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,606,255,000.00	2,606,254,895.00	1,590,000,000.00	1,590,000,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,606,255,000.00	2,606,254,895.00	1,590,000,000.00	1,590,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	453,886,300.00	453,192,113.75	759,504,800.00	759,504,186.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	424,783,500.00	424,783,128.30	747,225,400.00	747,224,786.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	424,783,500.00	424,783,128.30	747,225,400.00	747,224,786.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,102,800.00	28,408,985.45	12,279,400.00	12,279,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж			12,279,400.00	12,279,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	29,102,800.00	28,408,985.45		
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	950,400,000.00	14,975,000.00	-	-
2200	Дотоод эх үүсвэрээр	950,400,000.00	14,975,000.00	-	-
223001	Бусад хөрөнгө	950,400,000.00	14,975,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,049,906,670.00	8,114,481,670.00	5,134,464,300.00	5,134,464,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	9,049,906,670.00	8,114,481,670.00	5,134,464,300.00	5,134,464,300.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,049,906,670.00	8,114,481,670.00	5,134,464,300.00	5,134,464,300.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37.00	37.00	37.00	37.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	34.00	34.00	34.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан				